

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 06/268

НШУС

2006

ПЕТР БАДМАЕВ БА “ДОРНОД ХЯЗГААРЫН АМЬДРАЛ”

Ю.В.Кузьмин*

* ОХУ-ын Тайкалын эдийн засаг, эрх зүйн улсын их сургуулийн профессор, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D.)

Орчуулсан: проф. М.Зулькафиль.

Түлхүүр үг: “Дорнод хязгаарын амьдрал”, Дорно дахины төсөл, төвд эмч, “Жуд-ши”.

Төвдийн анагаах ухааны эмч Петр Александрович Бадмаев тал бүрийн авьяастай, ер бусын сонин хувь заяатай хүн байжээ. Энэ хүний үйл ажиллагаа, уран бүтээл, намтар нь харьцангуй бага судлагдсан бөгөөд 1990-ээд он хүртэл түүнийг судалгааны, уран зохиолын бүтээлүүдэд зөвхөн сүүдэртэй талаас нь харуулж байсан.

Эл өгүүлэлд түүний эрхлэн гаргаж байсан “Дорнод хязгаарын амьдрал” сонин болон нийтлэлийн үйл ажиллагааны талаар голлон өгүүлэхийг зорилго болгов. Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүйн судлалын сэтгүүлийн бодлогыг харгалзан үзсэн хэрэг бөгөөд энэхүү гайхамшигтай, дахин давтагдашгүй авьяаслаг сэхээтний бүх үйл ажиллагааны талаар нэг өгүүлэлд багтаан өгүүлэх боложгүй

юм. Эхлээд П.Бадмаевын намтраас товч өгүүлье.

Түүний буриад нэр нь Жамсран бөгөөд 1851 оны 4 дүгээр сарын 11-нд Өвөр Байгалийн Чит мужийн одоогийн Агийн буриадын үндэсний тойрогийн Табтанай хэмээх газарт жирийн нэг гэр бүлд төржээ. Том ах нь Сультим эмчлам байсан ба түүний төвдийн анагаах ухааны мэдлэгийг төрөлх нутгийнхан өндөр үнэлдэг байжээ. Жамсран ахаасаа төвдийн анагаах ухааны талаар олон зүйл суралцсан нь түүний ирээдүйн амьдрал, ажил төрөлд томоохон нөлөө үзүүлсэн ажээ.

Жамсрангийн аав Дунсунханов Бадам баруун буриадын хаосай омгоос гаралтай бөгөөд П.А.Бадмаевын бичсэнээр Чингисхааны удмын хүн юм. Үүнийг сүүлийн жилүүдэд П.А.Бадмаевын ач хүү, зохиолч Б.С.Гусев батлах оролдлого хийж, төвийн томоохон сонин хэвлэлд энэ талаар хэд хэдэн нийтлэл бичсэн байна. “Бадамын гэр бүлийнхэн

бол Чингисхааны эхийн талын найм дахь үеийн удмынхан мөн", "Засогол Бадам Чингис хааны өвөг дээдэс болох Добо Мэргэнээс гаралтай"¹, "Эмч-лам Бадмаев, Чингис хааны үр удам мөн"² гэж бичиж байсан нь үүний баталгаа юм.

Жамсран 14 хүүхдийн хамгийн бага нь байв. Дунд ах нь Ампил Петербургийн их сургуулийг төгссөн анхны Агийн буриадуудын нэг байжээ.

Жамсран 1864-1870 онд Эрхүүгийн сонгодог гимназид суралцаж, алтан медалиар дүүргэжээ.

Жамсрангийн том ах Сультим Бадмаев Өвөр Байгальд гарсан тахлыг эмчлэхэд гарамгай гавьяа байгуулсан учир 1857 онд Петербургт уригдаж, Николай цэргийн эмнэлгийн эмчийн туслахаар томилогдсон түүхтэй юм.

1860 онд бие дааж эмчлэх эрх авч, 1862 оноос цэргийн эмчийн бүх эрх мэдлийг эдлэх болж, цэргийн хэргэм цол хүртсэн ажээ. 1860 онд Петербургт төвдийн эмийн сан нээж, Оросын газар зүйн нийгэмлэгийн Дорнод-Сибирийн салбарын гишүүнээр сонгогджээ. 1864-1868 онд Петербургийн их сургуулийн Дорно дахины факультетэд монгол хэлний багшнаар ажиллаж байв. Сультим Бадмаевт туслах, үйл ажиллагааг залгамжлагч шаардлагатай

байсан тул дүү Жамсранг Петербургт ирүүлсэн бөгөөд 1870 онд Хааны анагаах ухааны академид элсэн суралцах болжээ. Сургалтын төлбөрийг төлж чадаагүй учир нэг жилийн дараа сургуулиас хасагджээ. Харин Дорнод-Сибирийн амбан захирагч Н.Н.Муравьев-Амурский тэтгэлэг хуваарилснаар Петербургийн их сургуулийн дорно да-

хины хэлний факультетийн монгол, манж, хятад хэлний ангид суралцах боломжтой болжээ. Онцсайн суралцаж, бүх улсын шалгалтыг амжилттай өгсөн Жамсранг Улсын шалгалтын комисс дэд эрдэмтний зэрэг хүртэх боломжтой гэж үнэлсэн байв. 1873 онд том ах Сультим нас барж, түүний эмийн

санг эзэмших болжээ. Их сургуулийг амжилттай дүүргэсний дараа Гадаад хэргийн яамны Азийн газрын 8 дугаар зэргийн түшмэлээр томилогдож, тэнд 1893 он хүртэл ажилласан байна. Энэ хугацаанд Монгол, Хятад, Төвдэд байнга очиж байсан бөгөөд төвдийн эмнэлгийн талаар тодорхой мэдлэг боловсролтой болох, янз бүрийн мэдээ материал цуглуулах боломж олгожээ.

1887 онд язгууртан гаралтай Надежда Васильевна Васильеватай

«

Сургалтын төлбөрийг төлж чадаагүй учир Жамсран нэг жилийн дараа сургуулиас хасагджээ. Харин тэтгэлэгт хамрагдсанаар Петербургийн их сургуулийн дорно дахины хэлний факультетийн монгол, манж, хятад хэлний ангид суралцах боломжтой болжээ. Онцсайн суралцаж, бүх улсын шалгалтыг амжилттай өгсөн Жамсранг Улсын шалгалтын комисс дэд эрдэмтний зэрэг хүртэх боломжтой гэж үнэлсэн байв.

»

гэрлэж богино хугацаанд амьдрал ахуйг сайжруулж, хувийн эзэмшлийн газар, хоёр давхар хувийн байшинтай болсон ажээ.

1872 оны 4 дүгээр сард христийн шашинд орж, өөрийнхөө шүтээн болсон Дугаа их Петр хааны нэрийг авч, Петр Александрович Бадмаев болжээ. Үүнд хоёр шалтгаан байв. Нэг талаар өөрийн том ах Сультим өмнө нь христийн шашинд орж, Александр Александрович болсон нь нөлөөлсөн бол, нөгөө талаар өөр үндэстэн хүн тухайн үеийн Орос оронд христийн шашинд орохгүйгээр албан тушаал дэвших, өөрийн гэсэн тодорхой байр суурийг эзлэх боломжгүй байжээ.

П. А.Бадмаевын үйл ажиллагааны гол чиглэл нь төвдийн анагаах ухаанаар эмчлэх, төвдийн анагаахын алдарт судар “Жүд-ши”-г орчуулах, нийтлэх, олон нийтэд тайлбарлан таниулах явдал байлаа. Петербургийн их сургуульд хятад, монгол, төвд, манж хэлийг сурсан нь энэ чиглэлээр амжилттай ажиллахад нөлөөлснөөс гадна Анагаах ухааны академийн бүрэн курсыг төгсөж европын анагаах ухааны талаар тодорхой мэдлэг эзэмшсэн нь олны дунд нэр хүнд олж авах, мэдлэгийн шинэ өндөрлөгт гарах боломж олгосон ажээ.

1898 онд П.А.Бадмаев “Төвдийн эмчилгээний ухааны системийн тухай”, 1903 онд “Төвдийн эмчилгээний ухааны үндсэн удирдамж: Жүд-ши” гэсэн хоёр ном хэвлүүлжээ.

П.А.Бадмаевын үйл ажиллагаа маш олон талтай, өргөн хүрээг хамарч байсны дотор төвдийн анагаах ухаан, дипломат, арилжаа наймаа, сурган хүмүүжил зэрэг ажил онцгой байр эзэлдэг. Тэрбээр XIX зууны эцэс, XX зууны эхэнд хааны болон төр, засгийн хүрээнийхний дунд нөлөө бүхий хүн байв. Хааны гэр бүлд ойр дотно байсан нь Алс Дорнодод хэд хэдэн төсөл хэрэгжүүлэх боломж олгожээ. Хааны гэр бүлийхэнтэй захидлаар чөлөөтэй харилцаж, санал бодлоо илэн далангүй солилцож байв. Эхлээд III Александр хаан, дараа нь түүний хүү II Николай хаанд шууд хандаж, захидал бичиж олон асуудлыг нааштай шийдвэрлүүлж байсан юм.

1893 оны 2 дугаар сарын 13-нд П.А.Бадмаев III Александр хаанд “Дорнод Ази дахь Оросын улс төрийн бодлогын зорилтуудын тухай” дэлгэрэнгүй төсөл бичсэн бөгөөд хаан төсөлтэй танилцаад 2 дугаар сарын 27-нд “Энэ бүхэн үнэхээр шинэ, ер бусын гайхамшигтай, амжилтанд хүрнэ гэдэгт итгэхэд бэрх юм”³ гэсэн тэмдэглэл хийсэн байдаг. Мөн “П.А. Бадмаев ба К⁰” хэмээх худалдааны танхим байгуулахад зориулж 2 сая рубль хүссэн өргөдлийг хаан нааштай хүлээн авч, 10 жилийн хугацаатай 4 хувийн хүүтэй өгөх шийдвэр гаргажээ. Ингээд 1893 оны 11 дүгээр сард Петербурgt Худалдааны танхим эх сууриа тавьж, түүний гол удирдах салбар нь Чита хотод байрлахаар болжээ. П.А.Бадмаевын худалдааны танхим

олон талт ажил явуулж байсны дотор хэвлэх үйлдвэр байгуулж, "Дорнод хязгаарын амьдрал" сониныг орос, монгол хэл дээр гаргаж эхэлсэн нь бидний сонирхлыг илүү ихээр татаж байна.

П.А.Бадмаев энэ сонины үйл ажиллагаанд онцгой анхаарч, эрхлэгч-орчуулагчаар нь буриадын соён гэгээрүүлэгч, Агийн мэргэжлийн сургуулийн багш Буд Рабданович Рабдановыг (1855-1923) ажиллуулж байжээ. Б.Рабданов мэргэжлийн сургууль, Читийн гимнази төгсөж, эхлээд Өвөр Байгалийн мужийн захиргаанд ажиллаж, дараа нь мэргэжлийн сургуульд багшлах болжээ. Монгол, Хятадад нэг биш удаа аялж, Г.Н.Потанины орчуулагч хийж, Парисд Агваан Доржиевийн хамт монголчуудын соёл, шашны талаар лекц уншиж байсан тухайн үеийн томоохон сэхээтнүүдийн нэг байв. Товчоор хэлбэл, сонины бэлтгэл сайтай, өндөр боловсролтой эрхлэгч гэж хэлж болно.

Оросын түүх бичлэгт "Дорнод хязгаарын амьдрал" (1895-1897) сонины тухай зөвхөн мэдээлэл төдий зүйл байдаг бөгөөд түүнийг тусгайлан судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн бүтээл өдий хүртэл гараагүй байна. Энэ тогтмол хэвлэлийн өвөрмөц онцлог нь Орост уйгаржин монгол бичгээр, мөн орос, монгол хоёр хэл дээр (материалуудыг сонины нүүрний зүүн талд нь орос, баруун талд нь монгол хэл дээр нийтэлдэг байв) хэвлэгдсэн анхны сонин байсанд оршино.

"Дорнод хязгаарын амьдрал" сонин Чита хотод, "Бадмаевын худалдааны танхим ба К⁰" компанийн хэвлэх үйлдвэрт хэвлэгддэг байв. Энэ сониныг хэвлэн гаргах болсон гол шалтгаан нь П.А.Бадмаевын Орос улсад Хятад, Монгол, Төвдийг нэгтгэхэд чиглэгдсэн асар том төслийг хэрэгжүүлэх явдалтай шууд холбоотой байжээ. Сонин Бадмаевын олон талт үйл ажиллагааны талаар мэдээлэх, Худалдааны танхимын ажил үйлсийг сурталчлах зорилготой байжээ.

Х арамсалтай нь бид сонины бүх дугаарыг олж чадаагүй юм. Харин сонины ихэнх дугаар нь Санкт-Петербургийн Шинжлэх ухааны Академийн номын сан, Эрхүүгийн их сургуулийн эрдэм шинжилгээний номын сан, Бүгд Найрамдах Буриад Улсын үндэсний архивд хадгалагдан үлджээ.

Энэ сонин А3 форматаар, 4-6 нүүртэй долоо хоногт 5 удаа (даваа, пүрэв гаригаас бусад өдөр) хэвлэгддэг байв. Сониныг захиалгаар тарааж, үүргийн худалдаагаар борлуулдаг байсан бөгөөд зөвхөн Агийн тойрогт гэхэд 600 захиалагчтай байжээ.

Сонины гол чиглэлийг бүх нийтийн, хөдөө аж ахуйн, худалдаа-үйлдвэрлэлийн, утга зохиолын, улс төрийн шинжтэй гэж тодорхойлж байсан боловч, П.А.Бадмаевын Худалдааны танхимд харьяалагдах үйлдвэр, байгууллагуудыг сурталчлах, Орос улсын Алс Дорнодод явуулах гадаад бодлогын асуудалд ихээхэн анхаарал тавьж байсан юм.

"Мартагдсан хуудаснуудын нэвтэрхий үгийн сан"-гийн ("Байкал" сэтгүүл, 1942. №2) мэдээллээс үзэхэд сонины хавсралт болгон жил бүр Өвөр Байгалийн эдийн засагт зориулж 4 номыг хэвлэн гаргаж байсан ажээ. Сонины орос эх бичвэрийн редактораар Читийн ардын сургуулийн захирал байсан А.И.Сниткин, монгол эх бичвэрийн редактораар Б.Р.Рабданов ажиллаж байв. Рабданов хоёр мэргэжлийн сургууль, Читийн гимнази төгсөж, төвд, хятад, англи, орос, монгол хэлийг бие дааж эзэмшсэн, шилдэг орчуулагч, хэл шинжлэлийн томоохон мэргэжилтэн байсан юм.

Сонин хоёр жил гаруй хугацаанд гарсан. П.А.Бадмаев сонин гаргах хүсэлтээ 1895 оны 5 дугаар сарын 16-нд гаргаж, албан ёсны эрхийг 10 дугаар сарын 23-нд авсан бөгөөд сонины туршилтын дугаар энэ оны эцэст гарчээ. Сонины нийтлэлийн тодорхой хэсгийг Орос улсын хэмжээний материалууд, төр засгийн албан ёсны баримт бичгүүд, тушаал, зарлиг эзэлж байв. Гэхдээ бүс нутгийн асуудлыг тусгасан нийтлэл голлож, Өвөр Байгалийн эдийн засгийн байдал, орон нутгийн үйлдвэр, худалдаа, мал аж ахуйн тухай мэдээлэл гол байр эзэлдэг байжээ. Мөн Бадмаевын Худалдааны танхимын практик үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулж, хөдөө аж ахуйн фермийн нээлт, Хиагт, Өргөө хоёрын хооронд шуудан холбооны станци, сүм

хийд, гуанз, зочид буудал байгуулсан талаар тогтмол мэдээлж байв.

Судлаач И.Г.Стрюченко "Оросын анхдугаар хувьсгалын болон "Оросын өмнөх үеийн (1895-1907) Алс Дорнодын хэвлэл" (1982) бүтээлдээ "Сониныг хэвлэн гаргах үйл ажиллагаа нэлээд эрчимтэй явагдаж, олон төрлийн ажлыг хамарч байв. Тухайн үед энэ хязгаар нутагт байсан хамгийн орчин үеийн хэвлэх үйлдвэрт хэвлэгдэж, сэтгүүлчид нь өндөр цалин авч, сонины редакцид ердийн ажилтнуудаас гадна япон, хятад болон бусад хэлний олон орчуулагчийг авч ажиллуулдаг байсан юм. Эрхлэгчид нь урьдчилсан ямар ч хяналтгүйгээр гадаадын олон сонин хэвлэлийг захиалахыг зөвшөөрдөг байв" гэж бичсэн байдаг.

П.А.Бадмаев Байгал нуураас Хятадын Ланчжоу-фу хот хүртэлх төмөр зам барих төслийн талаар нийтэлж, өөрийн санал бодлыг илэрхийлж байсан ч түүний хувилбар дэмжлэг авч чадаагүй бөгөөд Манжуураар дамжин өнгөрөх өөр хувилбарыг сонгожээ.

Сониныг монгол хэл дээр гаргасныг Оросын дорно дахин болон монгол судлаачид, эрдэмтэд идэвхтэй дэмжиж байв. Тухайлбал, академич В.П.Васильев, профессор А.М.Позднеев нарын санал, талархал, мөн Дорно дахины факультетийн оюутнуудын зарим нэр томьёог монгол хэл дээр оновчтой илэрхийлэх талаарх ажил хэрэгч санал бодлыг нийтэлж байжээ.

1896 оны 11 дүгээр сарын 29-нд уншигчдад хандсан захидал нийтлэгдэж, түүнд "Сүүлийн үед удахгүй тус сониныг урьдчилсан хяналтгүйгээр хэвлэхгүй, тэр ч байтугай хэвлэхийг хориглох болно гэсэн ор үндэсгүй цуурхал тарсан" тухай өгүүлжээ. Энэ захидал гарахаас өмнө сонины хэмжээ багасч, 6 нүүрийг 4 болгосон нь ийм цуурхал гарах үндэс болжээ. Мөн 10 дугаар сарын 7-нд П.А.Бадмаев хүүхдүүдээ сургах зорилгоор гэр бүлээрээ Петербург явсан байв.

Аажим аажмаар сонинд сонирхолтой, олны анхаарлыг татахуйц материал ба сайн зохиогчид дутагдаж эхэлжээ. Сонины эхний дугаарууд тухайн үеийн хувьд өндөр

үзүүлэлт болох 3000 хувиар хэвлэгдэж байсан бол дараагийн дугааруудаас эхлээд хувь нь багассан байна.

"Дорнод хязгаарын амьдрал" 1897 оны эхний хагас жилд гарч, 7 дугаар сарын 1-нд гаралтаа бүрмөсөн зогсоожээ. Сонины 116 дугаарт (1897.06.28): "Ерөнхий эрхлэгч-хэвлэн нийтлэгч Читад эргэж ирэх хүртэл, монгол эхийн шинэ редакторыг эрж олох хүртэл сонины үйл ажиллагааг зогсоох болно" гэж бичсэн байна. Энд нэг зүйлийг тэмдэглэж хэлэхэд судлаач С.И.Гольдфарбын "Сибир

рийн сонины ажил" (2002) номонд сонин 1897 оны 6 дугаар сарын 11-нд үйл ажиллагаагаа зогсоосон, Верхнеудинскэд хэвлэгдэж байсан зэрэг буруу ташаа мэдээлэл байгааг анхаарвал зохино.

Энэ үед сонин орон нутгийн захиргааны болон цэргийн байгууллагуудтай нэлээд зөрчилдөж эхэлсэн. Хувийн шинжтэй сонин байсан учраас нийтлэл нь бараг хяналтгүй гардаг байжээ. Тиймээс орон нутгийн засаг захиргааг зоригтой шүүмжилдэг байсан нь түшмэдэд таалагдаагүй юм. Өвөр Байгалийн цэргийн захирагч П.А.Бадмаевын тухай гомдол мэдүүлж, сониныг хяналтгүй гаргахгүй байхыг санал болгож байв. Сонин үндсэн хоёр шалтгааны улмаас

хаагджээ. Нэг талаар П.А.Бадмаевын Худалдааны танхим дампуурсан, нөгөө талаар Бадмаев, Рабданов хоёрын хооронд томоохон зөрчил үүссэн. Энэ талаар 1904 онд П.А.Бадмаев: "Буд Рабданов миний харьяанд 2,5 жил ажилласан, энэ хугацаанд ихээхэн өртөв тавьсан, өөрийнхөө хувийн эрх ашгийн үүднээс буруу зөрүү мэдээлэл тараасан"⁴ гэж бичсэн байдаг.

П.А.Бадмаев зөвхөн 1899 онд сониноо хаах тухайд өргөдлийг Хэвлэлийн асуудал эрхлэх ерөнхий газарт өгчээ.

«

Энэ үед сонин орон нутгийн захиргааны болон цэргийн байгууллагуудтай нэлээд зөрчилдөж эхэлсэн. Хувийн шинжтэй сонин байсан учраас нийтлэл нь бараг хяналтгүй гардаг байжээ. Тиймээс орон нутгийн засаг захиргааг зоригтой шүүмжилдэг байсан нь түшмэлүүдэд таалагдаагүй юм.

»

Миний бодлоор “Дорнод хязгаарын амьдрал” сонин түүхийн болон нийтлэлийн чухал эх сурвалж болохын хувьд тусгай судалгааны объект болох ёстой юм. Энэхүү өвөрмөц онцлог бүхий тогтмол хэвлэл цаашид сэтгүүл зүйн түүх судлаачид, монгол судлаачдын анхааралд өртөх болно гэдэгт найдаж байна.

“Дорнод хязгаарын амьдрал” сонин мөн чанарын хувьд Сибирь дэх анхны олон улсын сонин байсан бөгөөд П.А.Бадмаев энэ үйл ажиллагааны бас л анхдагч нь болсон түүхтэй юм. Тийм ч учраас тэрбээр Сибирийн болон Оросын түүхэнд мөнхрөн үлдэх болно.

П.А.Бадмаевыг Орост төвдийн анагаах ухааны чадварлаг эмч, орчуулагч, дипломатч, бизнесмен болохын хувьд сайн мэддэг ч хэвлэн нийтлэх үйл ажиллагааны талаар харьцангуй бага мэддэг. Харин Бадмаев өнөөдөр хүртэл бараг судлагдаагүй уран бүтээлийн асар их өвийг үлдээсэн билээ. Түүний гаргаж байсан “Дорнод хязгаарын амьдрал” сониныг судлах талаар дөнгөж анхны алхмыг хийсэн гэж хэлж болно. Бадмаев энэ сонины тэргүүн өгүүллүүдийг, мөн зарим бусад материалыг нийтэлж байсан юм. Түүнчлэн нөлөө бүхий улс төрчдөд хандаж бичиж байсан захидал, тэмдэглэл зэрэг асар их хэмжээний гар бичмэл үлдээснийг нэмж хэлэх хэрэгтэй.

Түүний уран бүтээлийн дотор янз бүрийн түүхэн шалтгааны улмаас бичигдсэн нийтлэлийн бүтээлүүд онцгой байр эзэлдэг. Тухайлбал, “Богд хааны эзэнт улс ба дэлхийн улс төрийн

бодлого” (1904), “Санхүү эдийн засгийн сайд С.Ю.Виттегийн арав дахь илтгэл ба Оросын хөдөө аж ахуйн амьдралын талаарх онолчид, практик ажилтнуудын үзэл бодол” (1902), “Бүх Оросын нөхөрлөлийн арми ба ард түмэнд туслах талаарх уриалгын цаг үеэ олсон нь” (1915), “Дайны төгсгөл” (1916), “Эрх чөлөө” (1917), “Оросын ард түмний мэргэн ухаан” (1917), “Удирдлагын ардчилсан хэлбэр” (1917) зэрэг томоохон бүтээлийг нэрлэж болно.

Зарим судлаач түүний бүтээлийг ач холбогдол багатай, цаг үеийн шинжтэй асуудлыг тусгасан төдий зүйл гэж үздэг тал бий. Гэхдээ түүний бүтээлийн утга зохиолын найруулга нь үнэхээр өвөрмөц бөгөөд нийтлэлийн гол үзэл санааг барьж авах нь тийм ч амар хялбар биш юм.

П.А.Бадмаев цаг үеийн чухал сэдвийг хөндсөн ном товхимлыг зөвхөн хэвлэн гаргаж байсан төдийгүй, тэднийг төрийн сайдууд, хааны гэр бүлд хүргэж байжээ. Тухайлбал, “Оросын ард түмний мэргэн ухаан” номыг хааны гэр бүлийнхэнд явуулахдаа II Николай хааны охидод захиа бичиж, Мария аливаа зүйлийг чин сэтгэлээсээ сурахыг эрмэлздэг “учраас энэ ном тус болно”, Анастасия номыг уншсанаар “манай эх орны 170 сая ард түмний дотоод ертөнцийг мэдэх гэсэн хүсэл төрөх болно” гэж бичжээ.

Түүний хаанд хандаж бичсэн тэмдэглэлээс бүрдсэн “Орос ба Хятад” номын агуулга нь Орос улсын Алс Дорнодод явуулж байгаа бодлогыг

шүүмжилж, Монгол, Хятад, Орос гурвыг тайван замаар нэгтгэх талаарх үзэл бодлоо илэрхийлсэн байдаг.

“Оросын ард түмний мэргэн ухаан” номонд зохиогч Оросын нийгмийн хямрал, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, түүнийг эрүүлжүүлэх, аврах арга замын талаарх үзэл бодлыг илэрхийлж, хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйг богино хугацаанд хөгжүүлэх талаар зоригтой алхам хийх шаардлагатай гэдгийг тусгаж байжээ.

Ийм нийтлэлийн бүтээлүүд П.А. Бадмаевын үйл ажиллагааны бага судлагдсан талыг харуулах бөгөөд зохиогчийн Орос орны улс төр, эдийн засаг, шашны хамгийн чухал асуудлуудад онцгой анхаарч байсны илэрхийлэл болох онцлогтой юм. Энэ бүтээлүүд онолын шинжтэй байсан төдийгүй, улс төрийн зорилтуудыг шийдвэрлэхэд нөлөөлж чадахуйц томоохон практик ач холбогдолтой байсан юм.

Ишлэл

¹ “Новый мир”. 1989. №11, с. 199.

² “Медицинская газета”. 1990. 29 апр.

³ Семенов В. П. 1925. За кулисами царизма (Архив тибетского врача Бадмаева). Л., с. 81.

⁴ АВПРИ, Китайский стол, ф. 143, опись 491, д. 564, л. 520.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Бадмаев П. А. 2001. За кулисами царизма: Воспоминания. Мемуары. Минск: Харвест, М.: АСТ.

2. Балданов С. С. 1994. О первой газете на бурятском языке // Национальная интеллигенция и духовенство: история и современность. Улан-Удэ.

3. Гольдфарб С. 2002. Газетное дело в Сибири: Первая половина XIX-нач. XX в. Иркутск.

4. Гусев Б. 2000. Крестник императора, целитель, дипломат. М.

5. Кузьмин Ю. В. 1991. П.А. Бадмаев: Врач, Ученый, Политик. Иркутск-Улан-Батор.

6. Кузьмин Ю. В. 2006. Восточные проекты доктора П.А.Бадмаева. Иркутск.

7. Семенов В. П. 1925. За кулисами царизма (Архив тибетского врача Бадмаева). Л., с. 81.

Резюме

Статья посвящена П.А. Бадмаеву (Жамрану) – неординарной личности и крупной политической фигуре Российской империи кон. XIX – нач. XX веков. Автор в статье главным образом обращает внимание на издательскую и публицистическую деятельность П.А.Бадмаева. Показывает некоторые особенности газеты “Жизнь на восточной окраине” и публицистических произведений П.А.Бадмаева. Автор статьи вводит в научный оборот уникальные материалы из архивохранилищ Москвы и Иркутска, на основе этих фактических материалов показывает мало известные аспекты многогранной деятельности П.А.Бадмаева. Выявление автором “белых пятен” в биографии изучаемого героя позволит в дальнейшем исследователям заполнить существующие пробелы и углубить представления читателей об изучаемой эпохе.